



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн
2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/179-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: А.Гэрэлмаа

Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|-------------------------------------|
| 1.Төрийн аудитын санал, дүгнэлт..... | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 8 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 10 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 10 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 11 |
| 3.Аудитын тайлан | 14 |
| 3.1. Ерөнхий зүйл..... | 14 |
| 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 14 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 15 |
| 3.4. Материаллаг байдал | 15 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 16 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт | 17 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 18 |
| 3.8 Аудитын гол асуудал | 18 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асудитын асуудал | 18 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 19 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 19 |
| 4. Аудитын илрүүлэлт..... | 19 |
| 4.1 Залруулсан алдаа | 19 |
| 4.2 Төлбөрийн акт | 20 |
| 4.3 Албан шаардлага | Error! Bookmark not defined. |
| 4.3 Зөвлөмж..... | 20 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 21 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СЭА | Сэлэнгэ аймаг |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ИТХТ | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/179-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

**СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 140,112,645.67 | 150,282,795.28 |
| 33 | АВЛАГА | 3,507,371.17 | 80.80 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 3,287,990.80 | 80.80 |
| 33500 | Бусад авлага | 219,380.37 | - |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 219,380.37 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 136,605,274.50 | 150,282,714.48 |
| 35100 | Түүхий эд материал | - | 799,600.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 585,000.00 |
| 35130 | Эм боох материал | - | 214,600.00 |
| 35400 | Хангамжийн материал | 136,605,274.50 | 149,483,114.48 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 266,000.00 | 313,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 499,050.00 | 1,016,050.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 160,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,380,920.00 | 568,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 141,600.00 | 265,400.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 132,317,704.50 | 147,160,364.48 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,124,191,303.00 | 1,148,040,396.57 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,124,191,303.00 | 1,148,040,396.57 |
| 39200 | Биет хөрөнгө | 940,822,302.89 | 958,726,396.42 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 766,007,185.68 | 766,007,185.68 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (89,033,253.12) | (134,108,676.12) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 324,670,833.43 | 255,254,097.58 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (201,179,541.52) | (120,183,206.37) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 192,301,210.83 | 207,978,878.27 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (108,002,594.52) | (72,495,357.61) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 26,697,691.50 | 26,697,691.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (9,230,642.29) | (11,907,447.79) |
| 39217 | Ном | 38,591,412.90 | 41,483,231.28 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 183,369,000.11 | 189,314,000.15 |
| 39301 | Програм хангамж | 2,046,178.00 | 6,545,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,821,177.89) | (374,999.85) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 183,144,000.00 | 183,144,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,264,303,948.67 | 1,298,323,191.85 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 219,380.37 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 219,380.37 | - |
| 41300 | Өглөг | 219,380.37 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 219,380.37 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,264,084,568.30 | 1,298,323,191.85 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,264,084,568.30 | 1,298,323,191.85 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 698,142,362.18 | 698,142,362.18 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | (656,345,898.18) | (619,975,717.53) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (611,897,124.74) | (654,214,341.08) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (44,448,773.44) | 34,238,623.55 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,222,288,104.30 | 1,220,156,547.20 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,264,303,948.67 | 1,298,323,191.85 |

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,241,099,478.53 | 1,300,626,125.10 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 53,432,851.63 | 113,062,043.33 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 53,432,851.63 | 113,062,043.33 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 20,217,087.39 | 96,183,465.17 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 33,215,764.24 | 16,878,578.16 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,187,666,626.90 | 1,187,564,081.77 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,114,308,200.00 | 1,075,848,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,114,308,200.00 | 1,075,848,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 9,514,000.00 | 16,932,680.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 11,588,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,514,000.00 | 5,344,680.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 63,844,426.90 | 94,783,301.77 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,844,426.90 | 94,783,301.77 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,285,370,951.97 | 1,266,387,501.55 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,285,370,951.97 | 1,266,387,501.55 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,207,051,720.86 | 1,219,545,335.60 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 876,957,045.86 | 863,953,247.90 |
| 210101 | Үндсэн цалин | 607,776,274.11 | 676,146,100.90 |
| 210102 | Нэмэгдэл | 205,400,922.15 | 170,979,896.00 |
| 210104 | Урамшуулал | 63,167,849.60 | 16,827,251.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 612,000.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 107,988,766.03 | 112,491,616.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,925,540.87 | 83,974,642.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,814,769.62 | 7,470,040.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,014,859.60 | 5,922,272.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,566,690.69 | 1,371,151.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,666,905.25 | 13,753,509.81 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 63,844,426.90 | 86,753,415.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,965,757.90 | 8,668,125.77 |
| 210302 | Түлш, халаалт | 46,800,109.00 | 71,267,944.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,078,560.00 | 6,817,346.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,155,627.57 | 14,289,216.54 |
| 210401 | Бичиг хэрэг | 905,500.00 | 1,006,900.00 |

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|------------------------|-----------------------|
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,200,000.00 | 440,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 685,240.00 | 3,064,670.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 15,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,827,750.00 | 891,854.54 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,354,200.00 | 4,141,891.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,167,937.57 | 4,743,901.00 |
| 2105 | Нормативт зардал | 8,769,140.00 | 6,103,540.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,100.00 | 130,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,940,740.00 | 4,677,940.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 528,300.00 | 1,295,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,295,904.00 | 16,802,206.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,295,904.00 | 16,802,206.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 538,210.00 | 486,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 538,210.00 | 486,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,272,840.00 | 7,309,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,302,840.00 | 6,157,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 1,152,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,250,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 122,229,760.50 | 111,356,793.24 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,494,300.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,983,339.35 | 6,170,221.64 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 114,752,121.15 | 105,186,571.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 78,319,231.11 | 46,842,165.95 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,359,605.00 | 35,175,976.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,782,605.00 | 33,685,976.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,577,000.00 | 1,490,000.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 51,959,626.11 | 11,666,189.95 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 51,959,626.11 | 11,666,189.95 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | (44,271,473.44) | 34,238,623.55 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 177,300.00 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 177,300.00 | - |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (44,448,773.44) | 34,238,623.55 |
| VI-I | Засгийн газрын хувь оролцоо | - | - |
| VI-II | Хяналтын бус хувь оролцоо | - | - |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,193,944,197.70 | 1,190,852,072.57 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,193,944,197.70 | 1,190,852,072.57 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,114,308,200.00 | 1,075,848,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,114,308,200.00 | 1,075,848,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 15,791,570.80 | 20,220,670.80 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 11,588,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,791,570.80 | 8,632,670.80 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 63,844,426.90 | 94,783,301.77 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,844,426.90 | 94,783,301.77 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,173,244,697.70 | 1,157,999,872.57 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,173,244,697.70 | 1,157,999,872.57 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,091,495,875.79 | 1,110,715,825.82 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 877,000,271.46 | 864,001,345.65 |
| 210101 | Үндсэн цалин | 607,819,499.71 | 545,563,309.25 |
| 210102 | Нэмэгдэл | 205,400,922.15 | 268,124,899.40 |
| 210104 | Урамшуулал | 63,167,849.60 | 50,313,137.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 612,000.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 107,988,767.43 | 112,443,518.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,925,552.83 | 78,847,579.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,814,769.61 | 8,802,300.02 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,014,848.95 | 6,925,296.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,566,690.74 | 1,633,496.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,666,905.30 | 16,234,846.02 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 63,844,426.90 | 86,390,215.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,965,757.90 | 8,668,125.77 |
| 210302 | Түлш, халаалт | 46,800,109.00 | 70,904,744.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,078,560.00 | 6,817,346.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,776,980.00 | 10,290,070.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,171,500.00 | 1,054,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,200,000.00 | 600,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 894,500.00 | 3,064,670.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 15,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,828,750.00 | 843,400.00 |

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|------------------------|------------------------|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,667,230.00 | 4,727,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 9,441,240.00 | 6,869,940.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,100.00 | 321,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,940,740.00 | 5,262,940.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,200,400.00 | 1,285,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,128,800.00 | 13,811,986.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 74,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 10,054,800.00 | 13,811,986.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 538,210.00 | 486,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 538,210.00 | 486,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,679,580.00 | 11,576,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,709,580.00 | 10,424,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 1,152,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,250,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,097,600.00 | 4,846,450.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,167,600.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,930,000.00 | 4,846,450.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81,748,821.91 | 47,284,046.75 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,501,205.00 | 35,617,776.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,924,205.00 | 33,809,776.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,577,000.00 | 1,808,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,287,990.80 | 80.80 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 3,287,990.80 | 80.80 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 51,959,626.11 | 11,666,189.95 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 51,959,626.11 | 11,666,189.95 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 20,699,500.00 | 32,852,200.00 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 20,699,500.00 | 32,852,200.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 20,699,500.00 | 32,852,200.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 20,699,500.00 | 32,852,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,699,500.00 | 32,852,200.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (20,699,500.00) | (32,852,200.00) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | - | - |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 698,142,362.18 | 1,225,154,616.24 | (614,763,636.68) | 1,308,533,341.74 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 2,866,511.94 | 2,866,511.94 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 698,142,362.18 | 1,225,154,616.24 | (611,897,124.74) | 1,311,399,853.68 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (2,866,511.94) | - | (2,866,511.94) |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 8 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | (44,448,773.44) | (44,448,773.44) |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 698,142,362.18 | 1,222,288,104.30 | (656,345,898.18) | 1,264,084,568.30 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 698,142,362.18 | 1,222,288,104.30 | (656,345,898.18) | 1,264,084,568.30 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 2,131,557.10 | 2,131,557.10 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 698,142,362.18 | 1,222,288,104.30 | (654,214,341.08) | 1,266,216,125.40 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (2,131,557.10) | - | (2,131,557.10) |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 34,238,623.55 | 34,238,623.55 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 698,142,362.18 | 1,220,156,547.20 | (619,975,717.53) | 1,298,323,191.85 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|-------------|--|-------------------------|-----------------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,198,942,000.00 | 1,158,965,211.82 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,198,942,000.00 | 1,158,965,211.82 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,162,724,000.00 | 1,124,285,435.82 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 871,148,700.00 | 864,001,345.65 |
| 210101 | Үндсэн цалин | 543,545,000.00 | 545,563,309.25 |
| 210102 | Нэмэгдэл | 277,281,000.00 | 268,124,899.40 |
| 210104 | Урамшуулал | 50,322,700.00 | 50,313,137.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 115,303,400.00 | 112,443,518.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,222,300.00 | 78,847,579.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,896,500.00 | 8,802,300.02 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,117,200.00 | 6,925,296.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,779,300.00 | 1,633,496.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,288,100.00 | 16,234,846.02 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 114,700,000.00 | 86,390,215.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,000,000.00 | 8,668,125.77 |
| 210302 | Түлш, халаалт | 83,000,000.00 | 70,904,744.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,700,000.00 | 6,817,346.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,874,200.00 | 9,753,470.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,019,200.00 | 1,019,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 600,000.00 | 600,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,185,400.00 | 3,064,670.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 851,300.00 | 851,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 543,400.00 | 543,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,674,900.00 | 3,674,900.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,607,000.00 | 1,607,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 321,400.00 | 321,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,285,600.00 | 1,285,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 42,762,800.00 | 42,761,986.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,000,000.00 | 12,000,000.00 |
| 210602 | Тавилга | 17,400,000.00 | 17,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,362,800.00 | 13,361,986.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 486,100.00 | 486,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 486,100.00 | 486,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,987,100.00 | 2,987,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,835,100.00 | 1,835,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,854,700.00 | 3,854,700.00 |

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,854,700.00 | 3,854,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,218,000.00 | 34,679,776.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 36,218,000.00 | 34,679,776.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 35,348,000.00 | 33,809,776.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 870,000.00 | 870,000.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,198,942,000.00 | 1,158,965,211.82 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,075,848,100.00 | 1,064,181,910.05 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | - | - |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,075,848,100.00 | 1,064,181,910.05 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 123,093,900.00 | 94,783,301.77 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 123,093,900.00 | 94,783,301.77 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 1,183 | 1,180 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 69 | 69 |
| 620001 | Удирдах ажилтан | 4 | 4 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 48 | 48 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 17 | 17 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 1,044 | 1,041 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 1,044 | 1,041 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,044 | 1,041 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 69 | 69 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 49 | 49 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1 | 1 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1 | 1 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 18 | 18 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|-------------|--|------------|----------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 20,220,670.80 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 20,286,570.80 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 19,348,490.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 1,387,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 35,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 1,052,900.00 |
| 2105 | Нормативт зардал | | 5,262,940.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 5,262,940.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 1,040,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 590,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 450,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 10,665,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 10,665,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 991,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 991,750.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 938,080.80 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 938,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 938,000.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 80.80 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | (65,900.00) |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | (65,900.00) |
| 223001 | Бусад хөрөнгө | | (65,900.00) |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 20,220,670.80 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 20,220,670.80 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 11,588,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 8,632,670.80 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн /цаашид Сүхбаатар сумын 2 дугаар сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын аудитор А.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь *"Сурагч нэг бүрийн сурах үйлийг дэмжиж, хоцрогдолегүй сургах, тэднийг хөгжүүлэх бүх талын хамтын ажиллагааг сайжруулснаар сурлагын чанарт ахиц гаргах"* гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа
- Иргэнд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах босго үнийг “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Монгол улсын засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор шинэчлэн хийгдсэн гэх мэт Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж санхүүгийн үйл ажиллагааг үнэн зөв илэрхийлэн зориулалтын дагуу зарцуулсан, бүртгэл хөтлөлт, шилэн дансны мэдээлэл байршуулалт хангалттай, сайн гэж үнэлэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,285,370.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,853.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 8,997.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,019.2 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөг/ | | |
|---|--------------------|--------------------|-----------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Хувь хүнээс авах авлага | - | - | - |
| Татаас санхүүжилтийн авлага | 3,288.0 | 0.1 | (3,287.9) |
| Байгууллагаас авах авлага | 219.4 | - | (219.4) |
| Урьдчилж төлсөн зардал | - | - | - |
| Бараа материал | 136,605.3 | 150,282.7 | 13,677.4 |
| Үндсэн хөрөнгө | 1,124,191.3 | 1,148,040.4 | 23,849.1 |
| Нийт хөрөнгө | 1,264,303.9 | 1,298,323.2 | 34,019.2 |
| Өр төлбөр | 219.4 | - | (219.4) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,264,084.6 | 1,298,323.2 | 34,238.6 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,264,303.9 | 1,298,323.2 | 34,019.2 |

Тайлант онд байгууллагаас авах авлага дансны эхний үлдэгдэл 3,507.4 мянган төгрөгийг барагдуулж, үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13,677.4 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 14,556.3 мянган төгрөгийн биологийн кабинетын сургалтын хэрэглэгдэхүүн болон төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хүнсний материал, аж ахуйн материал, хангамжийн материалын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 46,384.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр нийт 32,852.2 мянган төгрөгийн принтер, зөөврийн компьютер, шалгалтын материал засах программ хангамж, сурагч ширээ сандал, ном зэргийг худалдан авч, БШУЯ-аас 4,736.9 мянган төгрөгийн ширээ сандал, 1,765.8 мянган төгрөгийн ном, БСУГ-аас 208.8 мянган төгрөгийн ном зэрэг хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэсэн ба Сүхбаатар сумын ИТХТ-ийн 2021 оны 40 дүгээр тогтоолын дагуу 85,912.1 мянган төгрөгийн хөрөнгийг актлан данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 504 тоот зөвшөөрлийн бичгийг үндэслэн 89,471.9 мянган төгрөгийн анхны үнэ бүхий "0" үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглах хугацааг шинээр тогтоосон байна.

Тайлант онд ажиллагсдад өгөх 219.4 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулж, үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,298,323.2 мянган төгрөг болж 34,238.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,300,626.1 мянган төгрөг болж өмнөх оноос 59,526.6 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна. Энэ нь “0” үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглах хугацааг сунган, дахин үнэлж үнэ төлбөргүй орлогоор тайлагнаснаас шалтгаалсан байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,266,387.5 мянган төгрөг болж өмнөх оноос 18,983.5 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан. Энэ нь цалин, хоол, бараа үйлчилгээний бусад зардал хэмнэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 1,695,739.3 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 496,797.3 мянган төгрөгөөр бууруулан **1,198,942.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,198,942.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,075,848.1 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 123,093.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,075,848.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 94,783.3 мянган төгрөгийн санхүүжилт нийт 1,170,631.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,158,965.2 мянган төгрөгийг зарцуулан, 11,666.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,158,965.2** мянган төгрөг буюу 96.7 хувьтай тайлагнагдсан нь тогтмол зардал 28,309.7 мянган төгрөгөөр, цалингийн зардал 7,147.4 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 2,859.9 мянган төгрөгөөр, хоол 1,538.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 120.7 мянган төгрөгөөр, урсгал засвар 0.8 мянган төгрөг зэрэг нийт 14,964.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас ариутгалын 300.0 мянган төгрөг, бичиг хэргийн 150.0, Боловсролын чанарын шинэчлэл төслийн 10,600.0 мянган төгрөг зэрэг нийт 11,588.0 мянган төгрөг, тендерийн бичиг баримтын 35.0 мянган төгрөг, хоолны 8,632.7 мянган төгрөг, нийт 20,220.7 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.”* гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь *“цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%”* гэж заасан боловч сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан *“Түр журам журам батлах тухай”* тушаалын хоёрдугаар хавсралт *“Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”*-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд **1,198,942.0** мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр **1,158,965.2** мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.3 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 219.4 мянган төгрөгийн албан шаардлага, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 129,035.7 мянган төгрөгийн шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 184,983.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 38,396.3 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 271.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 146,315.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд үр дүнгийн тайланд 26,730.0 мянган төгрөгийн элэгдэл дутуу тусгасан, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 11,666.2 мянган төгрөгөөр бууруулан тайлагнасныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан багш Г.Түмэндэлгэрт 187.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, багш Т.Нямсүрэнд 84.3 мянган төгрөгийн илүү цагийн хөлс зэрэг нийт 271.3 мянган төгрөгийг илүү бодож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нэг удаагийн тэтгэмжийн 338.1 мянган төгрөгийг цалингийн зардлаас санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 145,977.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан

загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|---|----------------------|-----------|-----------|----------|---------------|-------|-----------------|-----|---------|-----------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль | 5 | 184,983.1 | 2 | 38,396.3 | 1 | 271.3 | | | 2 | 146,315.5 |